

3.2 Багшийн мэдээлэл засварлах

Багшийн мэдээлэл засах үйл явцын зааварчилгаа

Багшийн мэдээлэл засварлах үйлдлийг хийхээс өмнө системд дараах үйлдлийг хийсэн байх ёстой.

- Боловсролын удирдлага системд багш нэмэх үйлдлээр багшийг бүртгэсэн байх
- Багшийн заадаг бүх хичээлийг Хичээл хэсэгт үүсгэж, хичээлийг Хөтөлбөр, төлөвлөгөөнд нэмсэн байх
- Анги бүлэг хэсэгт бүлэг үүсгэхдээ хариуцсан багшийг (АУБ) тодорхойлсон байх
- Сургалтын орчин хэсэгт хичээлийн байр болон байранд харьяалагдах анги, танхимыг үүсгэсэн байх

Багшийн мэдээлэл оруулах үйлдлийг хийхэд дараах дарааллыг баримтлана. Үүнд:

1. **БУ системийн Багш** үйл ажиллагааг сонгоно.
2. Багшийн жагсаалтаас мэдээлэл оруулах багшийн нэрийг сонгоно.
3. Үйлдэл цэснээс **багшийн мэдээлэл** үйлдлийг дарна эсвэл жагсаалтаас багшийн нэр дээр дарна.
4. Багштай холбоотой бүлэг мэдээллийг оруулаад хадгална.

Багшийн мэдээлэл оруулах үйлдлийг хийх алхамчилсан дараалал дараах байдалтай байна.

Үйл ажиллагааны жагсаалтаас **Багш**-ийг сонгоход дараах цонх нээгдэнэ.

| № | Багшийн нэр | Төрөл | Албан тушаал | Төлөв |
|---|-------------|--------------------------|-------------------------------|----------|
| 1 | С.Адъяа | Дунд ангийн үндсэн багш | Багш, математикийн /1-р дунд/ | Идэвхтэй |
| 2 | О.Азаяа | Бага ангийн үндсэн багш | Багш, бага ангийн /1-р бага/ | Идэвхтэй |
| 3 | Ж.Азаяа | Бага ангийн үндсэн багш | Багш, бага ангийн /3-р бага/ | Идэвхтэй |
| 4 | Д.Алимаа | Бага ангийн үндсэн багш | Багш, бага ангийн /3-р бага/ | Идэвхтэй |
| 5 | О.Алимаа | Ахлах ангийн үндсэн багш | Багш, биологийн /1-р ахлах/ | Идэвхтэй |

Цонхны баруун дээд хэсэгт байрлах үйлдэл цэснээс **Багшийн мэдээлэл** үйлдлийг дарах эсвэл **багшийн нэр** дээр дарахад багшийн мэдээлэл харуулсан цонх нээгдсэний **мэдээлэл засах** товчийг дарахад дараах цонх дуудагдана.

БОЛОВСРОЛЫН УДИРДЛАГА

Багшийн мэдээлэл | З.Алимаа

ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ

Болх Хадгалаад хаах

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Нэр А
 Овог З:
 Регистрийн дугаар дн
 Албан тушаал Багш, техник, технологийн
 * Төрөл Дунд ангийн үндсэн багш
 * Салбар, бүрэлдэхүүн сумын бүрэн дунд сургу:
 САЗНэгж Дунд Ангийн Заах Аргын Нэгд:
 Удирдагч эсэх
 * Төлөв Идэвхтэй

Үндсэн мэдээлэл:

| | |
|----------------------------|---|
| Овог | Багшийн үндсэн мэдээллээс автоматаар татагдана. Засах боломжгүй байна. |
| Нэр | Багшийн үндсэн мэдээллээс автоматаар татагдана. Засах боломжгүй байна. |
| Регистрийн дугаар | Багшийн үндсэн мэдээллээс автоматаар татагдана. Засах боломжгүй байна. |
| Албан тушаал | Хүний нөөцийн системд ажилд авсан ажлын байрны нэр автоматаар татагдана. Засах боломжгүй байна. Хэрэв <u>албан тушаал буруу</u> бол хүний нөөцийн системийн ажилтны жагсаалт хэсэгт албан ажил эрхлэлт руу орж засах үйлдлээр засна. |
| Багшийн төрөл | Багш нэмэх үйлдлээр багш нэмэх үед сонгосон багшийн төрөл харагдана. Засах боломжтой байна. Хэрэв засах бол тухайн багш ямар төрлийн багш гэдгийг сонгоно. (Бага ангийн үндсэн багш, , мэргэжлийн багш гэх мэт) Сургуулийн хувьд багшийн хичээлийн дийлэнхийг аль боловсролын түвшинд зааж байгаагаас хамаарч багшийн төрлийг сонгоно. Анхаарах нь: Мэргэжлийн багш гэсэн нэр томъёо нь ихэвчлэн ХБК-ийн мэргэжлийн багш бүртгэхэд ашиглана. ЕБС-ийн хувьд бага, дунд, ахлах (үндсэн, цагийн) аль ангид дийлэнх хичээлийг орж байгаагаас шалтгаалж багшийн төрлийг сонгоно. Ингэснээр багштай холбоотой тайлан мэдээ зөв гарна. |
| Салбар, бүрэлдэхүүн | Багш нэмэх үйлдлээр багшийг нэмэх үед сонгосон салбар, бүрэлдэхүүн харагдана. Засах боломжтой байна. Сургалтын байгууллага нь салбар, бүрэлдэхүүнгүй бол салбар бүрэлдэхүүн нь сургалтын байгууллага байна. |

| | |
|-----------------------|---|
| САЗНэгж | Багш нэмэх үйлдлээр багшийг нэмэх үед сонгосон сургалт, аргазүйн нэгж харагдана. Засах боломжтой байна. |
| Удирдагч багш | Бүртгэж байгаа багш нь анги, бүлэг удирдсан, суралцагчид зөвлөх багшаар (их, дээд сургуульд ихэвчлэн тохиолддог) ажилладаг бол тэмдэглээ хийж Тийм гэсэн хариулт өгнө. Тэмдэглэгээ хийхгүй бол үгүй гэсэн хариултад тоолно. |
| Төлөв | Багш идэвхтэй эсвэл идэвхгүй төлөвтэй байгаа эсэхийг сонгоно. |
| Хадгалаад хаах | Хадгалах товчийг дарснаар мэдээлэл хадгалагдана. |